



#Санхүүгийнзохицуулаххороо

20

Жилийн тайлангийн  
нэгтгэлийн танилцуулга

20

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ  
үзүүлэгч



[WWW.FRC.MN](http://WWW.FRC.MN)



+976-51-264444



[info@frc.mn](mailto:info@frc.mn)

# Агуулга

1

Оршил

2

Хууль эрх зүйн зохицуулалт

3

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага



Статитик үзүүлэлт



Борлуулалтын тойм



Санхүүгийн тайлангийн үзүүлэлт



Эрсдэлийн үнэлгээ



Дүгнэлт

4

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид



Статитик үзүүлэлт



Борлуулалтын тойм



Санхүүгийн тайлангийн үзүүлэлт



Эрсдэлийн үнэлгээ



Дүгнэлт

5

Нэгдсэн дүгнэлт

---

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

СЗХ - Санхүүгийн зохицуулах хороо

ҮХХЗБ - Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага

ҮМҮЧЭТХЭАЭ - Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

МУТСТ - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх



# Оршил


Манай улсын хувьд санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болох хуульч, өмгөөлөгч, нотариатч, нягтлан бодогч нарын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүргийг тухайн салбарын хууль, журам болон 2013 онд батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулсаар ирсэн.

Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулснаа зарлаж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, тогтолцоог сайжруулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгөгдсөн. Мөн үл хөдлөх эд хөрөнгө зуучлал болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн статистик тоо мэдээлэл нь тодорхой бус, бүртгэл, зөвшөөрөл, хяналт, зохицуулалтгүй, мөнгө угаах эрсдэлд өртөх өндөр эрсдэлтэй гэж дүгнэсэн.

Үүний дагуу (ФАТФ)-ын 40 зөвлөмжид санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэдэгт үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах аливаа ажиллагаа, нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулан “Мэдээлэх үүрэгтэй этгээд” буюу гүйлгээн дэх мөнгөний эх үүсвэрийн талаар эрх бүхий байгууллагад тайлагнаж, холбогдох мэдээ, мэдээллээр хангадаг байх нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ гэж дүгнэсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчид болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулж зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, бүртгэл, хяналттай холбоотой харилцааг зохицуулсан журмуудыг баталж, тусгай зөвшөөрөл олгож бүртгэлжүүлээд байна.


Мөн Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх **Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлаар хийх ажлын хэсэг байгуулагдан анх удаа санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид буюу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн МУТС эрсдэлийн үнэлгээг боловсруулж байна.**






# Ерөнхий төлөв байдал


Зураг 1. Хороонд тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн хүсэлтийн тоо




## Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэсэн байдал




ТЗ хүсэлт




ХНХ, ХЭ бүтэц  
бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах  
хүсэлт



Агентын  
өөрчлөлтийн  
хүсэлт



Өргөдөл гомдол



Салбарын  
зөвшөөрөл

Салбарын зөвшөөрлийн хүсэлт 1	10-15 	409 	Тайлант хугацаанд нийт 659 санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдээс тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг Хороонд ирүүлснээс 62 хувь нь буюу 409 нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдээс ирсэн байна. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг дунджаар 10-15 хоногт шийдвэрлэсэн.
Хаягийн өөрчлөлтийн хүсэлт 4			
Нэмэлт бүтээгдэхүүн бүртгүүлэх 4	43 	207 	



# Хууль, эрх зүйн зохицуулалт


Хорооны зүгээс санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр 2020 онд дараах ажлуудыг хийсэн байна.

	Тогтоолын дугаар, өдөр	Журам, зохицуулалт
I улирал	2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоол	“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”
	2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 121 дүгээр тогтоол	Хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээ”-г тогтоосон
	2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 150 дугаар тогтоол	“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”
	2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 151 дүгээр тогтоол	Хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээ”-г тогтоосон
II улирал	2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 179 дүгээр тогтоол	“Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”
	2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 181 дүгээр тогтоол	“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”
	2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 182 дугаар тогтоол	“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”
IV улирал	2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1048 дугаар тогтоол	“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”



## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Зураг 2. Үл хөдлөх эд хөрөнгийн үйл ажиллагааны дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь






Сүүлийн жилүүдэд үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус салбар нь манай орны нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 6 орчим хувийг дунджаар бүрдүүлдэг.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үндэсний статистикийн хорооны 2019 оны ажиллах хүчний судалгааны тайлангаас харахад цалинтай ажиллагсдын сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хамгийн өндөр буюу уул уурхай, олборлолтын салбарт 1.4 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн үйл ажиллагааны салбарт 1.2 сая төгрөг байна.


Зураг 3. Ажиллагсдын сарын дундаж цалин болон орлого, салбар



20 нас хүртэл



21—30 нас



31—40 нас



40 нас дээш



## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага


Нийт 207 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас тусгай зөвшөөрөл хүсэж, холбогдох баримт бичгийг ирүүлсэнээс тайлант хугацаанд 167 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон байна. Сард дунджаар 18 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу хянаж Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлжээ.

Брокерын тоо <b>188</b>	
Агентын тоо <b>1171</b>	


Дархан-Уул, Орхон, Төв аймагт тус бүр 1 үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.



Зураг 3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон байдал. /Өссөн дүнгээр/



Зураг 4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агентын тоо дүүргээр




114  
ҮХХЗБ

47  
ҮХХЗБ

6  
ҮХХЗБ

5  
ҮХХЗБ

Нийт 234 хувьцаа эзэмшигч, 19.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.








## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Зураг 5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага /байршлаар/




Холбооны гишүүнчлэлгүй ҮХХЗБ



Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоонд гишүүнчлэлтэй ҮХХЗБ



Үл хөдлөх хөрөнгө бизнес эрхлэгчдийн Гүүр нэгдсэн холбоонд гишүүнчлэлтэй



Үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах

Үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх үйл ажиллагааг зуучлах





Үл хөдлөх эд хөрөнөгийн менежментийн үйлчилгээ

Үл хөдлөх хөрөнгийг худалдан авч засварлан борлуулах үйлчилгээ

Хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд хамаарна гэж үзсэн бусад үйлчилгээ



## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага



II улирал      III улирал      IV улирал



Худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлсэн ҮХХЗБ

Түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлсэн ҮХХЗБ



II улирал      III улирал      IV улирал

Хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж буй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд 2020 оны эхний хагас жилээс эхлэн ирүүлбэл зохих тайлан мэдээг сар, улирал, хагас, бүтэн жил тутам ирүүлж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлыг Монгол улс дотооддоо алдаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан бизнесийн байгууллагын үйл ажиллагааг сар гаруй хугацаанд зогсоосноор үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулах үйл ажиллагаа 23 хувиар, түрээслэх үйл ажиллагаа 59 хувиар тус тус буурсан байна.



## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

### 2020 оны эхний хагас

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 103 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 83 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 20 хуулийн этгээд хамрагдсан. Нийт 153 хувьцаа эзэмшигчийн 1,872,772.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 10,549,182.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байсан.

Эргэлтийн  
хөрөнгө

62 %

Эргэлтийн  
бус хөрөнгө

38 %

Мөнгөн  
хөрөнгө

22 %

Өр  
төлбөрийн  
хэмжээ

+ 5.7%

### 2020 оны жилийн эцэс

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 167 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 99 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 54 хуулийн этгээд, өмнөх улирлын үзүүлэлтээр 14 хуулийн этгээд тус тус хамрагдсан. Нийт 234 хувьцаа эзэмшигчийн 19,960,513.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 43,715,365.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байсан.

Эргэлтийн  
хөрөнгө

36 %

Эргэлтийн  
бус хөрөнгө

64 %

Мөнгөн  
хөрөнгө

10 %

Өр  
төлбөрийн  
хэмжээ

-45%

Тайлант хугацаанд гарсан өөрчлөлтүүд



2020 оны хагас  
жилтэй харьцуулахад  
тусгай зөвшөөрөлтэй  
ҮХХЗБ-ын тоо

62%




2020 оны хагас  
жилтэй харьцуулахад  
нийт хөрөнгийн  
хэмжээ

3X



2020 оны хагас  
жилтэй харьцуулахад  
өр төлбөрийн хэмжээ

2X





## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Хүснэгт 1. ҮХХЗБ-ын санхүүгийн тайлан мянган төгрөгөөр, хувиар


ҮЗҮҮЛЭЛТ	2020 онд	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>ХӨРӨНГӨ</b>	-	
Эргэлтийн хөрөнгө	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,362,088.25	10%
Дансны авлага	4,209,718.85	10%
Татвар, НДШ – ийн авлага	85,616.29	0%
Бусад авлага	4,663,571.66	11%
Бараа материал	834,148.22	2%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	854,847.64	2%
Бусад эргэлтийн хөрөнгө	872,463.40	2%
Эргэлтийн хөрөнгийн дүн	15,882,804.32	36%
Үндсэн хөрөнгө	14,570,328.89	33%
Биет бус хөрөнгө	1,010,085.90	2%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,712,185.81	13%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,747,355.01	13%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	692,605.42	2%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	27,832,561.03	64%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,715,365.32</b>	<b>100%</b>
Дансны өглөг	7,784,681.36	18%
Цалин, татвар, НДШ-ийг өглөг	1,574,658.85	-
Банкны богино хугацаат зээл	6,884,625.57	16%
Хүүний өглөг	271,083.60	1%
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	2,858,886.39	7%
Нөөц /өр төлбөр/	5,845.96	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	1,704,071.68	4%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	65,000.00	0%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	21,235,563.81	49%
Урт хугацаат зээл	2,388,332.50	5%
Нөөц /өр төлбөр/	101,024.80	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	168,099.60	0%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,746,078.00	6%
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>23,981,641.81</b>	<b>55%</b>
Өмч	19,660,513.19	45%
- хувийн	19,660,513.19	45%
Нэмж төлөгдсөн капитал	12,530.00	0%
	56,652.00	0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг	393,874.93	1%
Хуримтлагдсан ашиг	-389,850.70	-1%
Эздийн өмчийн дүн	19,733,723.52	45%
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>43,715,365.32</b>	<b>100%</b>



## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

2020 эхний хагас

2020 оны эцэс



Хүснэгт 2. ҮХХЗБ-ын орлого, үр дүнгийн тайлан хувиар

Үзүүлэлт	2020 онд
Нийт орлого	100%
Борлуулалтын орлого (цэвэр)	98%
Түрээсийн орлого	1%
Хүүний орлого	0%
Бусад орлого	1%
Нийт зардал	100%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	57%
Борлуулалт, маркетингийн зардал	7.6%
Ерөнхий ба удирдлагын зардал	31%
Санхүүгийн зардал	3%
Бусад зардал	1%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.01%
Тайлант үеийн цэвэр ашиг	168,497,040





# Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-д заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ҮХХЗБ-аас улирал бүр бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний асуулгыг, хагас жил болон бүтэн жилээр комплаенсын эрсдэлийн үнэлгээний асуулгыг авч Олон улсын валютын сангийн аргачлалын дагуу ҮХХЗБ-ын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлж байна.

<p><b>30%</b></p>	Байгууллагын <b>бүтцийн эрсдэлийн үнэлгээг</b> боловсруулахдаа тухайн байгууллагын онцлог шинж чанараас хамааруулан үнэлдэг.
<p><b>30%</b></p>	Байгууллагын <b>бизнесийн эрсдэлийг</b> тухайн тайлант хугацаанд үзүүлсэн үйлчилгээнээс хамааруулан үнэлдэг.
<p><b>40%</b></p>	Байгууллагын <b>комплаенсын эрсдэлийн үнэлгээг</b> боловсруулахдаа МУТСТ тухай хуульд заасан үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаагаас хамааруулан үнэлдэг.

## МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

	Эрсдэл бага	Дундаж эрсдэлтэй	Эрсдэлтэй
<p>Эрсдэл бага Эрсдэлийн үнэлгээгээр 1.1 доош оноо авбал</p>	<p>Эрсдэл бага</p> <p>20</p> <p>4</p>	<p>✓</p>	<p>✓</p>
<p>Дундаж эрсдэлтэй Эрсдэлийн үнэлгээгээр 1.1– 1.9 оноо авбал</p>	<p>Дундаж</p> <p>✓</p>	<p>64</p> <p>75</p>	<p>✓</p>
<p>Эрсдэлтэй Эрсдэлийн үнэлгээ 2 болон түүнээс дээш оноо авбал</p>	<p>Эрсдэлтэй</p> <p>✓</p>	<p>✓</p>	<p>2</p> <p>4</p>
<p>Үнэлэх боломжгүй Эрсдэлийн үнэлгээний аль нэг тайлант ирүүлээгүй тохиолдолд</p>	<p>2020 оны хагас жилд МУТС эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байгууллагын тоо</p> <p>2020 оны эцэст МУТС эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байгууллагын тоо</p>		


МУТС эрсдэлийг үнэлэх боломжгүй ҮХХЗБ тоо нэмэгдсэн байна.



МУТС эрсдэл багатай ҮХХЗБ-ын тоо буурсан байна.



МУТС дундаж эрсдэлтэй ҮХХЗБ-ын тоо буурсан байна.



МУТС эрсдэлтэй ҮХХЗБ-ын тоо 2 нэмэгдсэн байна.



## Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр хуульчлагдсантай холбоотойгоор 2020 онд нийт 207 байгууллагаас хүсэлт ирсэнээс оны эхний хагаст 103 байгууллагад, сүүлийн хагаст 64 байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон. Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт нийт 188 брокер, 1,171 агент үйл ажиллагаа эрхэлж байна. Сүхбаатар дүүрэгт хамгийн их буюу 55 брокер үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Хан-Уул дүүрэгт 491 агент үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн Орхон, Дархан-Уул, Төв аймагт тус бүр 1 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна.



Коронавирус /ковид—19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улс орон даяар 2020 оны 11 дүгээр сарны 12-ны өдрөөс эхлэн сар гаруй хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа эрхлээгүй, үйл ажиллагаа нь доголдсны улмаас үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авахад зуучлах үйлчилгээ 2020 оны эхний хагас жилтэй харьцуулахад 23 хувиар, түрээслэх, хөлслөх үйлчилгээ 59 хувиар тус тус буурсан.



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын 2020 оны хагас жилийн нэгтгэлд 103 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 83 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 20 хуулийн этгээд хамрагдсан. Нийт 153 хувьцаа эзэмшигчийн 1,872,772.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 10,549,182.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байжээ. Мөн оны жилийн эцсийн салбарын нэгтгэлд 167 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 99 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 54 хуулийн этгээд, өмнөх улирлын үзүүлэлтээр 14 хуулийн этгээд тус тус хамрагдсан. Нийт 234 хувьцаа эзэмшигчийн 19,960,513.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 43,715,365.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.



МУТС эрсдэлийн үнэлгээний асуулгыг 2020 оны эхний хагаст 103 ҮХХЗБ ирүүлснээс 20 нь эрсдэл багатай, 64 нь дундаж эрсдэлтэй, 2 нь эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол 17 байгууллагын МУТС эрсдэлийг үнэлэх боломжгүй байжээ. Харин 2020 оны жилийн эцэст нийт 167 ҮХХЗБ ирүүлснээс 4 нь эрсдэл багатай, 75 нь дундаж эрсдэлтэй, 4 нь эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол 84 байгууллагын МУТС эрсдэлийг үнэлэх боломжгүй байна. Оны эцэст эрсдэл багатай байгууллагын 5 дахин буурч, дундаж эрсдэлтэй байгууллагын тоо 10 хувиар нэмэгдсэн бол эрсдэлтэй байгууллагын тоо 2-оор нэмэгдсэн байна.







## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид

Монголбанк 2020 онд 26.6 тн алтыг 2.9 их наяд төгрөгөөр худалдан авсан. Энэ нь өмнөх онтой харьцуулбал алтны худалдан авалт 54 хувиар өссөн байна.

Монголбанкинд алт тушаасан харилцагчид хувиар




Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ





Эх сурвалж: Монголбанкны цахим хуудас

Үндэсний статистикийн хороотой хамтран үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн судалгааг улс даяар 2020 онд хийж гүйцэтгэсэн. Тус судалгаанд нийт 1,253 этгээд хамрагдсан.








Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид байршлаар




Хөдөө орон нутаг  
Улаанбаатар






## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид


Тайлант хугацаанд 43 хуулийн этгээд, 409 иргэнээс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлсэн. Үүнээс 30 хуулийн этгээд, 399 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн /ҮМҮЧЭТХЭАЭ/ тусгай зөвшөөрлийг олгосон байна.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон байдал /өссөн дүнгээр/



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч иргэн /өссөн дүнгээр/



Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн /өссөн дүнгээр/



## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид



20

хуулийн этгээд



8

хуулийн этгээд




2

хуулийн этгээд

Нийт 46 хувьцаа эзэмшигчийн 8,198,319.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид /байршлаар/



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд

### Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭА нар







Аймаг	Иргэдийн тоо
Увс аймаг	2
Ховд аймаг	5
Баянхонгор аймаг	14
Өвөрхангай аймаг	1
Өмнөговь аймаг	8
Дорноговь аймаг	1
Төв аймаг	11
Дархан-Уул аймаг	7
Сэлэнгэ аймаг	19
Говь-алтай аймаг	4
Нийт	72




Салбар нээн ажиллуулах зөвшөөрлийг 1 хуулийн этгээдэд олгосон.



## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид



Мөнгө худалдаж авсан үнийн дүн



Мөнгө зарсан үнийн дүн





## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 8 хуулийн этгээд 100 хувь нэгтгэлд хамрагдсан бөгөөд 12 хувьцаа эзэмшигчийн 3,463,622.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 8,073,760.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн.

2020 оны  
эхний хагас

Эргэлтийн  
хөрөнгийн дүн

51.4%

Эргэлтийн бус  
хөрөнгийн дүн

48.6%

Мөнгөн  
хөрөнгө

7.4%

Өр төлбөрийн  
хэмжээ

+11.3%

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 30 хуулийн этгээд нэгтгэлд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 18, эхлэлтийн тайлангаар 10, өмнөх улирлын үзүүлэлтээр 2 хуулийн этгээд хамрагдсан. Мөн 46 хувьцаа эзэмшигчийн 8,198,319.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 18,372,609.73 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

2020 оны  
эцэст

Эргэлтийн  
хөрөнгийн дүн

62%

Эргэлтийн бус  
хөрөнгийн дүн

35%

Мөнгөн  
хөрөнгө

10%

Өр төлбөрийн  
хэмжээ

51.3%

### Тайлант хугацаанд гарсан өөрчлөлтүүд

Богино хугацаат  
өр төлбөрийн дүн



62%

Хуримтлагдсан  
ашиг



54%

Үндсэн хөрөнгө



13%

Эргэлтийн  
хөрөнгө



11%




## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид

Хүснэгт 3. ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн санхүүгийн тайлан /мян.төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны жилийн эцэс	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>ХӨРӨНГӨ</b>		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,813,169.39	10%
Дансны авлага	3,248,956.50	18%
Татвар, НДШ – ийн авлага	216,308.18	1%
Бусад авлага	993,298.95	5%
Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0%
Бараа материал	2,432,516.99	13%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	392,164.12	2%
Бусад эргэлтийн хөрөнгө	202,436.52	1%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	2,080,013.36	11%
Эргэлтийн хөрөнгийн дүн	11,378,864.01	62%
Үндсэн хөрөнгө	6,414,324.42	35%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	574,432.70	3%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,993,745.72	38%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,372,609.73</b>	<b>100%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.00</b>	<b>0%</b>
Дансны өглөг	3,609,502.17	20%
Цалингийн өглөг	27,000.15	0%
Татварын өр	153,237.77	1%
НДШ - ийн өглөг	15,053.60	0%
Банкны богино хугацаат зээл	1,388,334.20	8%
Хүүний өглөг	0.00	0%
Урьдчилж орсон орлого	760,538.78	4%
Бусад богино хугацаат өр төлбөр	2,274,196.42	12%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,227,863.10	45%
Урт хугацаат зээл	1,000,727.06	5%
Бусад урт хугацаат өр төлбөр	185,228.80	1%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,185,955.86	6%
Өр төлбөрийн нийт дүн	9,413,818.96	51%
Өмч	8,198,319.05	45%
- хувийн	8,198,319.05	45%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	46,496.30	0%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,686,331.33	9%
Хуримтлагдсан ашиг	-972,355.91	-5%
Эздийн өмчийн дүн	8,958,790.77	49%
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>18,372,609.73</b>	<b>100%</b>



## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид



Хүснэгт 4. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн орлого, үр дүнгийн тайлан хувиар

2020.12.31	
Нийт орлого	100%
Борлуулалтын орлого (цэвэр)	98%
Түрээсийн орлого	0%
Хүүний орлого	0%
Бусад орлого	2%
Нийт зардал	100%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	37%
Борлуулалт, маркетингийн зардал	30%
Ерөнхий ба удирдлагын зардал	28%
Санхүүгийн зардал	1%
Бусад зардал	4%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0%
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-128,993,580 ₮





## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид

Хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-д заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээсулрал бүр бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний асуулгыг, хагас жил болон жилийн эцэст комплаенсын эрсдэлийн үнэлгээний асуулгыг авч арилжаа эрхлэгч тус бүрийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдлийг тодорхойлж байна.



Байгууллагын **бүтцийн эрсдэлийн үнэлгээг** боловсруулахдаа тухайн байгууллагын онцлог шинж чанараас хамааруулан үнэлдэг.




Байгууллагын **бизнесийн эрсдэлийг** тухайн тайлант хугацаанд үзүүлсэн үйлчилгээнээс хамааруулан үнэлдэг.



Байгууллагын **комплаенсын эрсдэлийн үнэлгээг** боловсруулахдаа МУТСТ тухай хуульд заасан үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаагаас хамааруулан үнэлдэг.

### МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

	Эрсдэл бага Эрсдэлийн үнэлгээгээр 1.1 доош оноо авбал
	Дундаж эрсдэлтэй Эрсдэлийн үнэлгээгээр 1.1– 1.9 оноо авбал
	Эрсдэлтэй Эрсдэлийн үнэлгээ 2 болон түүнээс дээш оноо авбал
	Үнэлэх боломжгүй Эрсдэлийн үнэлгээний аль нэг тайланг ирүүлээгүй тохиолдолд



2020 оны эхний хагаст 8 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийсэн. 2020 оны эцэст нийт 30 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийлээ. МУТС эрсдэлийн үнэлгээгээр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байгууллага байхгүй байна.



2020 оны эхний хагас



2020 оны эцэс



## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид



2020 оны эхний хагаст үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 8 хуулийн этгээд, 304 иргэнд тусгай зөвшөөрөл олгосон бол 2020 оны сүүлийн хагаст 22 хуулийн этгээд 95 иргэнд тусгай зөвшөөрөл олгосон байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 65 хувь нь Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байна. Сэлэнгэ аймагт 19, Баянхонгор аймагт 14, Төв аймагт 11, Өмнөговь аймагт 8 иргэн тус тус үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь 2020 оны 2 дугаар улиралд 322,402,032.5 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний алтыг, 3 дугаар улиралд 450,120,340.6 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний алтыг, 4 дүгээр улиралд 235,206,153.9 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний алтыг тушаасан байна.

2020 оны 3 дугаар улиралд 129,5 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг худалдан авч, 458,5 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг худалдсан бол 4 дүгээр улиралд 11,8 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг худалдан авч 54,1 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг зарсан байна.



2020 оны эхний хагаст 8 хуулийн этгээдийн нийт орлого 800 сая байсан бол 2020 оны жилийн эцэст 30 хуулийн этгээдийн нийт орлого 2,7 тэрбумд хүрсэн байна. Оны эхний хагаст нийт орлогын 75 хувийн борлуулалтын орлого эзэлж байсан жилийн эцэст нийт орлогын 98 хувийг борлуулалтын орлого эзэлж байна. 2020 оны эхний хагаст нийт зардлын 49 хувийг маркетингийн зардал, 39 хувийг ерөнхий ба удирдлагын зардал эзэлж байсан бол жилийн эцэст ерөнхий ба удирдлагын зардал 39 хувийг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 37 хувийг тус тус эзэлж байна. Тайлант үеийн цэвэр ашиг өмнөх үетэй харьцуулахад 900 хувиар өссөн байна.



2020 оны эхний хагаст 8 хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээг боловсруулсан бөгөөд 2 нь эрсдэл багатай, 5 нь дундаж эрсдэлтэй, 1 хуулийн этгээдийн хувьд үнэлэх боломжгүй гэж үнэлэгджээ. 2020 оны жилийн эцэст 30 хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээг боловсруулснаас 5 нь эрсдэл багатай, 8 нь дундаж эрсдэлтэй, 17 нь үнэлэх боломжгүй байсан. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн хувьд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байгууллага байхгүй байна.





# Нэгдсэн дүгнэлт



Тайлант хугацаанд СЗХ-ны 24 удаагийн хуралдаанаар 607 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Тухайлбал, зохицуулалтын орчинг бий болгох ажлын хүрээнд 5 журам баталж, 4 тогтоолд өөрчлөлт оруулсан. Тусгай зөвшөөрөл олгох ажлын хүрээнд 167 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 30 хуулийн этгээд 399 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Харин 2 хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, 1 хуулийн этгээдэд салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн. Хороонд бүртгэлтэй 167 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь 188 брокер, 1,171 агенттайгаар үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн байна.



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид зайны болон газар дээрх хяналт, шалгалтын журмын хавсралтын дагуу санхүүгийн тайлан, МУТС-ийн эрсдэлийн үнэлгээний тайлан, үндсэн үйл ажиллагааны мэдээ болон мэдээлбэл зохих гүйлгээ, харилцагчийн мэдээллийг журамд заасан хугацаанд Хороонд тайлагнахаар журамласан.

Тайлан мэдээг хүлээн авах орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд 13 төрлийн тайлан, мэдээний мастер файлыг боловсруулж, тайлан нэгтгэлийн Фина системд метадатаг өрсөн. Улмаар зохицуулалттай 2 салбарын 2020 оны эхний хагас жилийн тайланг Фина системээр хүлээн авч эхэлсэн.



Тайлант хугацаанд давхардсан тоогоор 215 ҮХХЗБ нь нийт 610.3 мянган м.кв талбай, 281.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, худалдан авч, шилжүүлсэн бол давхардсан тоогоор 126 ҮХХЗБ нийт 88.6 мянган м.кв үл хөдлөх хөрөнгийг 39.9 тэрбум төгрөгөөр хөлслүүлж, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучилсан байна. Мөн Хороноос тусгай зөвшөөрөл олгосон 167 ҮХХЗБ нь 43.7 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй, 20.0 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ба цэвэр ашиг 0.17 тэрбум төгрөгтэй байна.



Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд нийт 577.0 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдаж, 624.0 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдан авсан бол 517.4 сая төгрөгийн мөнгө худалдаж, 235.2 сая төгрөгийн мөнгө худалдан авсан байна. Харин 1,207.1 сая төгрөгийн үнэ бүхий үнэт эдлэлийг худалдаж, худалдан авсан байна. Мөн Хороноос ҮМҮЧЭТХЭАЭ тусгай зөвшөөрөл олгосон 30 хуулийн этгээдүүд нь 46 хувьцаа эзэмшигчийн 8.2 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 18.4 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй ба цэвэр ашиг -0.13 тэрбум төгрөгтэй байна.